

# НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ БОЛОН БАЙГАЛЬ ЭКОЛОГИЙН ҮР ДҮН



Стратеги төлөвлөгөө нь хамт олныг нэг зорилго чиглэлд зангидах гол хэрэгсэл болно. Хамт олон байгууллагын хөгжлийн төлөө зөв хандлага, сэтгэлтэй болох нь энэ байгууллага урт хугацаанд тогтвортой ажлын байраар намайг хангаж чадах уу, үгүй юү, энэ байгууллага дотор би карьерийн хувьд хөгжих бололцоо байна уу, миний нийгмийн баталгаа хэр байгаа вэ гэдэг асуултуудад ажилтнууд хариулт авч чадсанаар хандлага тогтож, өөрийгөө дайчлан чармайж эхэлнэ. Эдгээр асуултуудад хариулах, тэдэнд итгэл үнэмшил өгч чадах хэрэгсэл нь стратеги төлөвлөгөөний баримт бичиг байх юм.

Уг стратеги төлөвлөгөөний хүрээнд тодорхойлогдож байгаа нэг шинэлэг зүйл нь компани өнөөгийн бизнесийн үйл ажиллагааны загвараа өргөжүүлэн диверсификаци хийж, төмөр замын

ашиглалт, тээвэрлэлтийн үйлчилгээний чиглэлүүдийг үндсэн бизнес болгох өргөжилтийн стратегийг санал болгож байгаа явдал юм. Чухамхүү ийм стратегийг барьснаар компанийн үйл ажиллагааны цар хүрээ төлөвлөлтийн үеүдэд эрс өсөж, ашиг хуримтлал нь эрс нэмэгдэх боломж бүрдэнэ. Харин хөгжлийн ийм стратегийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны өргөжилтийг хийж чадахгүй бол нэгд, өнгөрсөн жилүүдэд бүрдсэн дэд бүтэц, хүний нөөцөө бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй, хоёрт одоогийн бизнесийн эрэлтийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан манай хамт олон жижиг хэмжээний компанийн статусаас цааш ахиж чадахгүй байх, эсвэл цаг алдах сул талтай байна.

## **Компанийн үйл ажиллагааны өргөжилт, эдийн засгийн үр дүн**

Стратеги төлөвлөгөөнд тодорхойлж байгаагаар “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замыг 2022 оны 7-р сард, “Чойбалсан-Хөөт - Бичигт”-ийн төмөр замыг 2025 онд тус тус ашиглалтад оруулж, улмаар замын хүчин чадлыг эзэмшихээр төлөвлөж байгаа нь ойрын 10 жилд компанийн үйл ажиллагааны хүрээ, орлого, ашиг хуримтлал эрс нэмэгдэх үе болохоор байна. Эдгээр бүтээн байгуулагдсан төмөр замын дэд бүтцээ ашиглан тээвэрлэлт, суурь бүтцийн ашиглалтаа хэрэгжүүлдэг болох нь компанийн 2050 он хүртэлх хөгжлийн гол суурийг тавих юм. Зөвхөн эдгээр үйл ажиллагааны хүрээнд компанийн бизнесийн нийт үр дүнг тодорхойлбол дараах байдлаар харагдаж байна.

## Стратеги төлөвлөгөөний хугацаанд гол чиглэлийн төмөр замын цогц бизнесийг эзэмшсэний эдийн засгийн нийт үр дүн:

Шаардлагатай хөрөнгө оруулалт **3,337.71** сая ам.доллар



Нийт орлого **18,270.36** сая ам.доллар

Нийт зардал **8,531.15** сая ам.доллар

Улсад төлөх нийт татвар **840.47** сая ам.доллар

Нийт НДЭДШ **1334.55** сая ам.доллар



Нийт ажиллагсдын тоо **2542** хүн

Нийт ачилт, буулгалт / баяжуулсан нүүрс, бусад төрлийн ачаа ороогүй/ **1,134.60** сая тонн

Нийт тээвэрлэх ачаа **1581.85** сая тонн

Нийт цэвэр ашиг **7,564.19** сая ам.доллар



“Тавантолгой - Гашуунсухайт” чиглэлийн төмөр замыг ашиглалтад оруулснаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК болон Тавантолгойн сав газар дахь уулуурхайн компаниудын экспортын хэмжээ 2 дахин нэмэгдэж, борлуулалтын дүн 7.47 тэрбум ам.долларт хүрч, төсөвд татвар хураамжийн байдлаар төвлөрөх орлого 619 сая ам.доллараар

нэмэгдэх нөлөөлөл гарахыг “Тавантолгой - Гашуунсухайт”-ын төмөр замын бүтээн байгуулалтын ТЭЗҮ-ийн 2020 оны тодотголоор тооцон гаргасан байна. Зүүн бүсэд байгуулах төмөр замын төслийн хувьд уг бүсэд тогтоогдсон ихээхэн хэмжээний ашигт малтмалын нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө

оруулалт татах чадварыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхээр байна. Ингэснээр уг бүсийн хөгжилд асар их дэвшил авчрах нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой.



## Нийгэм, байгаль - экологийн үр дүн

Компанийн урт хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нийгмийн хөгжлийн дараах эерэг үр дүнгүүд гарах болно. Үүнд:

- Зам, тээврийн сүлжээ, харилцаа холбоо, төлбөр, тооцооны үйлчилгээ чанарын шинэ түвшинд хүрнэ. Цахилгаан, усан хангамж зэрэг орчин үеийн хийц, загвар техник, технологи бүхий дэд бүтцүүд бий болж нийгмийн зорилтот бүлэгт үйлчлэх болно.

- Авто тээврийн хэмжээ буурснаар осол эвдрэл, саатал багасаж, хөдөлгөөний аюулгүй байдал дээшилнэ.

- Ажилтнуудын мэдлэг мэргэжлийг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу байнга дээшлүүлэн хөгжүүлнэ.

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурьшлын бүсийг Тавантолгой өртөө болон Гашуунсухайт өртөөний орчимд барина. Тавантолгойн суурьшлын бүс нь 20 орчим га талбайд баригдах энд бөгөөд 830 орчим айлын орон сууцны хотхон, 640 хүүхдийн сургууль, 150 хүүхдийн цэцэрлэгийг барьж байгуулна. Мөн суурьшлын бүсэд эмнэлэг, олон нийтэд зориулсан спорт цогцолбор, үйлчилгээний

барилгууд, соёлын төвүүдтэй байх юм. Харин Гашуунсухайт дахь 360 айлын орон сууцны хотхоныг хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 4 га талбайд байгуулахаар төлөвлөсөн бөгөөд үүнтэй уялдуулан 100 хүүхдэд зориулсан сургууль, цэцэрлэг,



төмөр замын бүтээн байгуулалтыг дагаж дараах хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн дэвшил гарахаар байна. (Зураг 10)

Нийт ажилтан (байнгын ажлын байр) 11,555



бусад холбогдох үйлчилгээний төвүүд байгуулагдана.

- Компанийн ажилтнууд болон тэдний гэр бүл тогтвортой орлоготой байх нөхцөл бүрдэнэ.

- Ажилтнууд, тэдний гэр бүл эрүүл чийрэг байх, эрч хүчтэй ажиллах орчин болох амралт, сувиллын газартай болсон байна.

- Зөвхөн “Тавантолгой - Гашуунсухайт” чиглэлийн

Зураг 10. Шинээр бий болох ажлын байрны тоо

Компанийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарах байгаль - экологийн ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Төмөр зам дагуу хүн, мал, амьтны гарц, үерийн уснаас хамгаалах далан суваг тэдний хөдөлгөөний замд аль болохуйц саад болохгүйгээр тавигдана.

- Байгаль орчин, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа мэргэжлийн, байгальд ээлтэй түвшинд хийгдэх тул бүс нутгийн байгальд сөрөг нөлөө үзүүлэх аюул, ослын эрсдэл буурна.

- Газрын гадаргын эвдрэл, хөрсний элэгдэл, агаарын тоосжилт, ургамлын доройтол буурч, газрын нөөцийн болон бэлчээрийн ашиглалтад сөрөг нөлөө үзүүлэхгүй болно.

- Дизель хөдөлгүүртэй галт тэрэг нь тэр орчмын замаар явах ижил хэмжээний ачаа бүхий автомашины хөдөлгүүрээс ялгарах хорт бодистой харьцуулахад 15 дахин бага байх тул агаарын бохирдол багасна.

- Шинэ санаа, инноваци нэвтэрч, хүрээлэн байгаа байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа боловсронгуй болно.

- Байгаль хамгаалалын удирдлага, зохион байгуулалт олон улсын нийтлэг жишгийн дагуу хэрэгжиж төмөр замын засвар үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах талаар үлгэр жишээч манлайлах үүрэгтэйгээр ажиллаж байгаль-экологийн доройтлыг бууруулахад том хувь нэмэр оруулна.







хандлагыг Монгол улсын урт хугацааны бодлого “Алсын хараа - 2050”-ын хүрээнд судалж, дүгнэн, компанийн хөгжлийн үзүүлэлтүүдийг харьцуулах суурь болгон, судалгаануудыг оруулсан болно.

**5.** Дотоод орчны оношилгоогоор компанийн өнөөгийн үйл ажиллагааг бизнесийн загварчлал гарган шинжилж, цаашид эрхлэх боломжит бизнесүүдтэй харьцуулан дүгнэлт гаргасан. Мөн удирдлагын бүтэц, хүний нөөцийн өнөөгийн байдал, цаашдын хандлага болон санхүүгийн удирдлагын нөхцөл байдлыг оношлон дүгнэлт гаргаж ажилласан болно. Энэхүү оношилгоо дүгнэлтээс үзэхэд компанийн бизнесийн өнөөгийн хэлбэр нь төслийн удирдлагын үйл ажиллагаанд тулгуурласан, цаашид хэрэгжих боломжтой үйл ажиллагааны чиглэл боловч цар хүрээ багатай, эрэлт хэрэгцээ, түүнээсээ хамааран санхүүгийн үр

дүн нь хязгаарлагдмал байгаа бөгөөд компанийн олон жилийн тогтвортой хөгжлийг хангах чиглэл дангаараа байх боломжгүй нь харагдаж байна. Иймээс бүтээн байгуулалт явагдаж буй “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын ашиглалтыг хариуцах, тээвэрлэлтийн үйл ажиллагааг үндсэн бизнес болгох, одоогийн үйл ажиллагаануудыг дэмжих чиглэл болгох нь оновчтой гэсэн дүгнэлтэд хүрч байна.

**6.** Компанийн урт хугацааны бодлогыг стратегийн хүрээ, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хяналт мониторингийн үзүүлэлтүүдээр дамжуулан илэрхийлсний хамт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, томоохон арга хэмжээнүүдийг төлөвлөлтийн үе шатуудаар зааглан тодорхойлсон нь уг төлөвлөгөөний үйл ажиллагаануудын дотоод логик, уялдаа, холбоотойгоор хэрэгжих боломжийг хангасан

гэж үзэж байна.

**7.** Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах шалгуурыг уг төлөвлөлтийн хяналт мониторингийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад гарч болох эрсдэлүүд, эрсдэлийг бууруулах арга хэлбэр зэргийг төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлон оруулснаар бүрдүүлж байгаа болно. Мөн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл нь компанийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, засаглалын тогтолцоог үе шаттайгаар шинэчлэх явдал гэж үзэн төлөвлөлтийн бүх үе шатуудад хэрэгжих удирдлагын зохион байгуулалтын загваруудыг гаргалаа.

**8.** Стратеги төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах үүднээс цаашид авч хэрэгжүүлэх 5-аас доошгүй хөтөлбөр, төслүүдийг боловсруулахаар төлөвлөж байгаагаас “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн хөтөлбөрийг боловсруулж, стратеги төлөвлөгөөний нэг үндсэн хавсралт материал болгон оруулж байна.

**9.** Стратеги төлөвлөгөөнд туссанчлан тус компани бизнесийн үйл ажиллагааны чиглэлүүдээ олон тулгууртай болгож чадвал төлөвлөлтийн хоёр, гуравдугаар үе шатнаас эхлэн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас олсон ашиг хуримтлалаараа төмөр замын бодлогод туссан зарим төслүүдийн санхүүжилтийг биеэ даан хийх эсвэл зарим бүтээн байгуулалтын хэсгийг өөрөө хийснээр бусад санхүүгийн эх үүсвэрүүдийг татах боломжийг нэмэгдүүлэх үр дүнтэй байхаар байна.

**10.** “Тавантолгой төмөр зам” ХХК нь 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээр төслийн удирдлагын үйл ажиллагаа эрхэлж буй өнөөгийн статусаас үе шаттайгаар хөгжин төмөр замын ашиглалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ үзүүлдэг үндэсний ба олон улсын түвшинд байр сууриа эзэлсэн том хэмжээний групп компани болох боломж байгаа юм.

**11.** “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх нь улс орны хөгжлийн томоохон төслүүдийн хэрэгжилтийг хангах, уул

уурхайн бүтээгдэхүүний экспорт, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, өмнөд болон зүүн бүсийн хөгжлийн боломжийг өргөтгөх зэрэг нийгэм, эдийн засгийн олон талын ач холбогдолтой байна.

**12.** Тус компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төмөр замын төслүүдийн бүтээн байгуулалтыг хийснээр тэдгээрийн хэрэгжиж буй бүс нутгийн хүн ам, нийгмийн дэд бүтцийн хөгжлийн тулгуур нөхцөлийг сайжруулж, байгаль экологи, хүрээлэн буй орчныг доройтуулахгүйгээр эдийн засгийг эрчимтэй эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлэх юм.

**13.** Мөн олон улсын төмөр замын тээврийн коридоруудыг үүсгэн, хөрш улсуудтай холбогдсон эдийн засгийн коридоруудыг бүтээн байгуулахад далайцтай хувь нэмэр оруулах болно.

